



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/540

Хэрлэн сум

“Ай Ти Эм-2023” Олон улсын  
аялал жуулчлалын үзэсгэлэнд  
оролцож, хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Олон улсын хэмжээнд аймаг орон нутгаа сурталчилан таниулах, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 27-оос 2023 оны 10 дугаар сарын 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Мишээл экспод зохион байгуулагдах “Ай Ти Эм-2023” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсугай.

2. Үзэсгэлэнд оролцоход шаардагдах 8,574,000 (найман сая таван зуун далан дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

3. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

5. Үзэсгэлэнд аймаг орон нутгаа сурталчилж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог хангаж, хариуцлагатай, өндөр зохион байгуулалттай оролцохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Мөнх-эрдэнэ)-д, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 10 дугаар сарын 20-ны  
А/540 дугаар захирамжийн хавсралт

“Ай Ти Эм -2023” үзэсгэлэнд  
оролцох зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт дүн ₮
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	м <sup>2</sup>	18	150 000	2 700 000
2	А-5 Хэмжээтэй зурагт танилцуулга ном хэвлэл	ш	1200	3 500	4 200 000
3	Зурагт номын эх бэлтгэл	А5 нүүр	16	50 000	800 000
4	Талбай тохижилтын ажилд даавуу, стикер хэвлэлүүд болон бусад дагалдах материалууд		Даавуу, приус мод, скоч, уяа, тууз, хадаас, стикер, хөөсөнцөр г.м.		874 000
	<b>Нийт дүн</b>				<b>8 574 000</b>